

ХОЛБОО, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ХӨГЖИЛ БА БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГЫН МЕНЕЖМЕНТ

Г.ГАН-ЭРДЭНЭ

Хилийн цэргийн 0151 дүгээр ангийн захирагч, Хил судлалын докторант, хурандаа

Хураангуй: Монгол Улсын харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын төрийн бодлого боловсруулагч, зохицуулагч, оролцогч бүх талуудын хөгжлийн хүрсэн түвшин, үндсэн статистик үзүүлэлт, индикаторыг судлан дүн шинжилгээ хийж, ХХБ-ын холбоо, мэдээллийн технологи, кибер аюулгүй байдлын чиглэлийн хөгжлийн чиг хандлагыг харгалзан байгууллагын цаашид баримтлах хөгжлийн бодлого, төлөвлөлт, зорилтоо шинэчлэн тодорхойлно.

Түлхүүр үгс: Холбоо, мэдээллийн технологийн хөгжил, ХХБ-ын холбоо, мэдээллийн технологийн системийн удирдлага зохион байгуулалт

Мэдээлэл, харилцаа холбооны технологи (МХХТ)-ийн хөгжил нь бидний амьдралын хэв маяг, хандлага, ертөнцийг үзэх үзлийг өөрчилж, бид ч тэдгээр өөрчлөлт, тэр дундаа шинэ технологийн хэрэглээнд улам бүр дасан зохицсоор байна. Олон зууны туршид хүмүүсийн харилцааны гол хэрэглүүр нь цаасан дээр хичээнгүйлэн бэхээр бичдэг захидал байсан. Тэгвэл өнөөдөр үзэг цаас нийлүүлэн захидал бичихийн оронд гар утаснаасаа

зурвас илгээх, эсвэл компьютерын ард суугаад цахим шуудан илгээх төдий алба, амины бүхий л ажлаа амжуулах болсон байна. Компьютер ашиглах, тухайлбал баримт бичиг, мэдээллийг компьютероор боловсруулах, үүрэн холбоо хэрэглэх, интернэт ашиглах зэрэг нь манай өнөөгийн нийгмийн өдөр тутмын зайлшгүй хэрэгцээ, шаардлага болсон. Ажлын ямар ч зар дээр “Компьютерын өргөн хэрэглээний программ хангамжуудыг өндөр түвшинд эзэмшсэн байх” гэсэн шаардлага тавьдаг нь үүний наад захын жишээ юм.

М Х Х Т - и й н

х ө г ж л и й н ч и г х а н д л а г а н ь

- Цахим системүүд (e-systems): цахим боловсрол (e-education); цахим бизнес (ebusiness) цахим арилжаа (e-commerce); цахим засаглал (e-governance); цахим эрүүл мэнд (e-health)


- Мобайл системүүд (Mobile, m-systems): мобайл арилжаа (m-commerce); мобайл бизнес (m-business)

- Юбиктос системүүд (Ubiquitous, u-systems): юбиктос арилжаа (u-commerce); юбиктос бизнес (u-business)

- Гар утас, компьютер төдийгүй бүх л электрон төхөөрөмжийг интернэтэд холбон, хоорондоо дата солилцдог ухаалаг сүлжээг бий болгох Юмсын интернэт (Internet of Things)- ийн салбар сүүлийн үед улам бүр хөгжиж байгаа билээ.

Судалгаагаар дэлхийн интернэт хэрэглэгчдийн тоо улам бүр өссөөр байгаа ч ирэх жилүүдэд сүлжээг хэдэн тэрбум амьгүй “хэрэглэгчид” ашиглана гэсэн дүгнэлт гарчээ. Мэдээж энэ бол бидний өдөр тутам

хэрэглэдэг хөргөгч, автомашин, бичил долгион зуух, цахилгаан зуух, телевизор, гар утас, цаашилбал гутал хувцас, аяга таваг зэрэг ахуйн хэрэглээний эд зүйлс байх болно.



ХХМТ-ийн салбарын бусад улсаас хэрэгжүүлж буй арга хэмжээ, туршлагыг судлахад БНХАУ, ХБНГУ, Канад, Сингапур улсуудад дижитал шилжилтийн үйл явц эрчимжиж, үүнийг даган дэвшилтэт технологийн нэвтрэлттэй холбоотой шинэ ажлын байрууд бий болж, өгөгдлийн шинжээчид, хиймэл оюун ухаан болон машин сургалтын мэргэжилтнүүд, мэдээллийн аюулгүй байдлын шинжээчид, их өгөгдлийн болон дижитал шилжилтийн мэргэжилтнүүдийн эрэлт хэрэгцээ улам бүр нэмэгдэх хандлагатай байна. Түүнчлэн аналитик сэтгэлгээ, инновацын ур чадвар, идэвхтэй суралцах, сурах стратеги, асуудлыг цогцоор нь шийдвэрлэх ур чадвар, бүтээлч-өвөрмөц байдал, санаачилга, манлайлал зэрэг ур чадваруудын эрэлт өндөр байна.

Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичиг

“Алсын хараа 2050”, Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр 2020–2024, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын стратеги төлөвлөгөө 2021–2024 зэрэг бодлогын баримт бичгүүдэд нийгэм, эдийн засгийн бүхий л салбарт мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, хүний нөөцийг хөгжүүлэх, чадавхжуулах талаар холбогдох арга хэмжээг тусгасан байна.

Мэдээлэл технологийн хөгжлийн хурдац бидний амьдралд асар богино хугацаанд дадал хэвшил болон сууж, сошиал медиа, андройд төрлийн гар утас, сүлжээ, үүлэн тооцооллын үйлчилгээнүүдийн аюулгүй байдлыг хангах түүнээс учирч болох эрсдэлийг бууруулах нь өнөө үеийн чухал асуудлын нэг боллоо. Эрдэмтэн судлаачид дэвшилтэт технологийн чанар чансаа сайжрахын хирээр аюулгүй

байдлын эрсдэл нэмэгдэж, зохион байгуулалттай стратегийн шинж чанартай болсон гэж үзэж байгаа юм. Мэдээллийн орон зайд удирдлагыг авсан тал нь цэрэг, улс төрийн давуу байдлыг тогтоож чадах ба удирдлага, төлөвлөлтийн автоматжуулсан системийн хэвийн ажиллагааны бага гэлтгүй зөрчил, доголдол нь эдийн засгийн асар их хохирлыг дагуулж, мэдээллийн дэд бүтцийг гэмтээдэг. Иймээс цахим мэдээллийн аюулгүй байдал, түүний эрсдэлийг бууруулах арга зам, боломжийг зөв тодорхойлох шаардлага тулгарч байна.

Иймд Хил хамгаалах байгууллагад холбоо, мэдээллийн системийн аюулгүй байдлыг хангахад нөлөөлөх хүчин зүйлсийг тооцох, холбоог тасралтгүй найдвартай хангах, системийг улам боловсронгуй болгох шаардлага тулгарч байна.

Мөн байгууллагын мэдээллийн аюулгүй байдлыг хангах ажил нь зөвхөн энэ чиглэлийн алба хаагчдын ажил биш бөгөөд судалгаанаас харахад мэдээлэл алдалтын 80% нь тухайн мэдээлэлтэй харьцаж байгаа хүний зан үйл, мэдлэгийн асуудлаас шалтгаалсан байдаг байна. Өөрөөр хэлбэл байгууллагын алба хаагчдын холбоо, мэдээллийн технологийн мэдлэг, чадвараас шууд хамаарна.

Хил хамгаалах байгууллагын холбооны системийн өнөөгийн байдлын шинжилгээ

Мэдээлэл дамжуулах үйлдлийг холбоо гэнэ. Цэрэг зэвсгийг удирдахад зориулсан холбоог цэргийн холбоо гэнэ. Холбооны гол

үүрэг нь гэнэтийн аюулын тухай дохио өгөх явдал байдаг.

Холбооны төрөл гэдэг нь дамжуулж байгаа мэдээний төрлөөр нь ялгаж ангилсан бүлэг юм. Цэргийн холбоо нь телефон холбоо, телеграфын холбоо, өгөгдөл дамжуулах /факсимал/ холбоо, зурагт телефон холбоо гэсэн төрлүүдтэй.

Телефон холбоо нь харилцагчийн хооронд яриа явуулах болон телефон мэдээ дамжуулахад зориулагдана. Телефон холбоо нь дотроо нууцалсан болон ил телефон холбоо гэж хуваагдана.

Телеграфын холбоо нь үсэг тоон утгатай мэдээллийг дамжуулахад ашиглагдана. Телеграфын холбоог сонсголын болон үсэг хэвлэгч телеграф гэж хуваах ба аль нь ч ил болон нууцалсан байж болно.

Өгөгдөл дамжуулах систем нь автомат удирдлагатай системд мэдээлэл дамжуулахад зориулагдана. Хөдөлгөөнгүй дүрс дамжуулах /факсимал/ холбоо нь төрөл бүрийн зураг, бүдүүвч дамжуулахад зориулагдсан. Зурагт телефон холбоо нь яриа, дүрс, хөдөлгөөнийг зэрэг дамжуулахад оршино.

Цэргийн холбооны гарал гэдэг нь тархах орчин ба хэрэглэгдэх хэрэгслээр нь ялгаж ангилсан бүлэг юм. Цэргийн холбоо нь шууд радио холбоо, радиорелейний холбоо, агаар мандлын /тропосфер/ холбоо, сансрын холбоо, утсан холбоо, дохионы болон зарлага шуудан холбоо гэсэн гаралтай.

Холбооны систем нь цэргийн удирдлагын материаллаг үндэс болдог бөгөөд холбооны системд тавигдах шаардлагууд нь түүнийг байгуулах нөхцөл болно.

Холбоог төлөвлөх, зохион байгуулж хангах явцад холбооны системийг үнэлэх хэрэгцээ байнга гардаг. Холбооны чанар ба холбооны системийн үнэлгээ нь түүнд тавигдах шаардлагууд бодит нөхцөлд хэрхэн хангагдаж байгаагаар тодорхойлогдоно.

Цэрэг-техникийн өндөр хөгжилтэй орнуудад цэргийн холбоог зохион байгуулах аргад дараах өөрчлөлт орж байна. Холбоог радио, радиорелей, шим мандлын болон утсан холбоо гэх мэтээр холбооны гарлаар нь зохион байгуулдаг аргаас сувгийн стандартаар нь бүлэглэн зохион байгуулах аргад шилжиж байна. Цэргийн удирдлагын автоматжуулсан сүлжээг өргөнөөр зохион байгуулж байна.

Цэргийн холбоог зохион байгуулж буй аргадаа үндэслэн холбоо, мэдээллийн системийг стратеги, тактик, ар тал, хангалтын болон байлдааны ажиллагааны, театрт холбоо хангах зориулалтаар байгуулж байгаа бөгөөд түүний дотор нэгтгэл, ангийн холбоог зохион байгуулах асуудал багтаж байна. Цэргийн холбоог зохион байгуулах, түүний системийг байгуулахад орчин үед орж буй өөрчлөлт нь мэдээлэл, холбооны техник хэрэгслийн хөгжлийн өнөөгийн хүрсэн түвшин, ашиглалтын онцлогтой холбоотой гэдгийг анхаарах шаардлагатай.

Цэргийн холбооны системд байнгын бэлэн байдалд, тогтворт чанартай, мэдээллийг өнгөрүүлэх чадвартай, хөдөлгөөнтэй, аюулгүй байдал хангагдсан байх шаардлага тавигддаг.

Хил хамгаалах байгууллагын холбооны системийн өнөөгийн байдлыг судалсны үндсэн дээр түүнд шинжилгээ хийж үзвэл:

Эрх зүйн орчны хувьд

“Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”, “Монгол Улсын Төрөөс хилийн талаар баримтлах бодлого”, “Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого /2017-2025/”, тогтоол “Мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр” “Монгол Улсын “Монгол Улсын Хилийн тухай”, “Монгол Улсын Батлан хамгаалах тухай”, “Зэвсэгт хүчний тухай”, “Дайны байдлын тухай”, , “Радио долгионы тухай”, “Харилцаа холбооны тухай”, “Шуудангийн тухай”, “Төрийн болон албаны нууцын тухай”, “Гамшгаас хамгаалах тухай”, **“Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай”, “Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай”, “Цахим гарын үсгийн тухай”, “Кибер аюулгүй байдлын тухай хуулиуд, Засгийн газрын “Төрийн албаны интернэтийн зохистой хэрэглээний тухай”, “Төрийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай”, “Төрийн байгууллагуудын цахим мэдээллийн сан ашиглах тухай”**

тогтоол, Монгол Улсын “Төрийн цэргийн байгууллагын хөгжлийн стратеги-2030”, “Стратегийн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”, “Монгол Улсын хилээр нэвтэрч байгаа зорчигч, тээврийн хэрэгслийн нэгдсэн санг ашиглах, мэдээлэл харилцан солилцох журам”, “Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлах хугацаа, жилд байгуулах элэгдлийн хэмжээ”, “Тамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам”, “Тусгай хэрэглээний мэдээлэл, холбооны сүлжээ байгуулах, ашиглах журам” зэрэг нь байнгын үйл ажиллагаандаа ашиглах бодлого, хууль, эрх зүйн орчин тодорхой хэмжээгээр бүрдсэн, тэдгээрийг ашиглаж хэвшсэн байна.

Гэвч нийгэм тэр дундаа мэдээллийн технологи маш хурдтай хувьсан өөрчлөгдөж байгаа өнөө үед Хилийн цэргийн холбоо, мэдээллийн системд мөрдөгдөж байгаа зарим удирдлагын баримт бичгүүд дутагдалтай болж, нэмэлт өөрчлөлтүүдийг оруулах, шинээр заавар, журмууд гаргаж албанд ашиглах зайлшгүй шаардлагатай тулгарч байна. Өөрөөр хэлбэл Хил хамгаалах байгууллагын хууль эрх зүйн орчны шинэчлэл мэдээлэл, харилцаа холбооны технологийн хөгжлийн хурднаас хоцорсон байна.

Энэ нь Улс эх орны нийгэм, эдийн засгийн хөгжлийн чадавхаас хамаарч хилийн аюулгүй байдал алдагдаж, шинэ төрлийн хилийн зөрчлийг илрүүлэх магадлал буурч,

хөрш улсын хил хамгаалалтын хөгжлөөс хоцрох, төрийн цэргийн болон тусгай чиг үүргийн байгууллагуудын мэдээллийн нэгдсэн тогтолцоо бүрдээгүйгээс харилцан ажиллагаа, түүний аюулгүй байдал хангалтгүй, байгууллагын мэдээллийн аюулгүй байдлын хөндлөнгийн хяналт сул, хилийн шалган нэвтрүүлэх албаны сервер цахим халдлагад өртөх зэрэг эрсдэлүүдийг дагуулж байна.

Хэдий тийм боловч 2021 оны 12 сарын 17-ны Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай, Цахим гарын үсгийн тухай, Кибер аюулгүй байдлын тухай хуулийн төслүүдийг эцэслэн батлагдсан нь холбоо, мэдээллийн технологийн эрхзүйн шинэчлэл хийх орчин нөхцөл бүрдсэн, мөн Хил хамгаалах байгууллага нь онолын түвшинд холбоо, мэдээллийн технологийн асуудлыг бүрэн судалж, судалгааны ажлыг эргэлтэд оруулах, судлаачдыг бэлтгэх зэрэг боломжууд харагдаж байна.

Хил хамгаалах байгууллага нь 2008 онд “Хилийн цэргийн холбооны заавар”-ыг гаргасан бөгөөд одоог хүртэл нэмэлт тодотгол оролгүйгээр холбоо зохион байгуулалтын үндсэн удирдлага болгож ирсэн. Энэ нь нь Хууль эрхзүйн орчны шинэчлэл технологийн хөгжил, нийгмийн хэрэгцээ шаардлагаас хоцрох үндсэн шалтгаан болсон бөгөөд орчин үеийн шаардлагад нийцсэн, техник технологийн хөгжилтэйгөө хөл нийлсэн эрхзүйн орчныг

байгууллагын хэмжээнд бүрдүүлэх шаардлагатай болох нь харагдаж байна.

Бүтэц, орон тооны хувьд:

ХХБ-ын холбоо, мэдээллийн нэгдсэн систем нь цэргийн удирдлагын тогтолцооны хүрээнд удирдамж, тушаал шийдвэрийн дагуу үйл ажиллагаа явуулдаг, стратегийн болон оператив түвшинд гадаад, дотоодод бэлтгэгдсэн ажлын тодорхой туршлага бүхий хүний нөөцтэй.

Мөн өндөр хөгжилтэй орнуудад цэргийн холбоо, мэдээллийн офицер ахлагч нар суралцан мэргэжил боловсролоо дээшлүүлж байгаа;

Сургалт бэлтгэлийг гадаад, дотоодын их сургуулиудад явуулахаас гадна өөрийн харьяаны Хилийн цэргийн 0151 дүгээр ангийн Холбооны сургалтын төвийг түшиглэн зохион байгуулдаг.

Гэвч 2023 онд хийгдсэн судалгаагаар:

- Бүтцийн нэгжүүд, тасгуудын орон тооны нөхцөл байдлын судалгаанаас үзэхэд нийт орон тооны 19,5%-д нь мэргэжлийн бус хүн томилогдсон, 15,6% буюу 48 орон тоо сул, нийт шаардлагатай мэргэжилтэн 108 хүн буюу нийт орон тооны 35,06% нь мэргэжлийн боловсон хүчнээр дутмаг;

- Инженер, техникч, холбоочин мэргэжилтний үнэлэмж бага;

- Бусад байгууллагын мэргэжилтнүүдтэй харьцуулахад Хил хамгаалах байгууллагын холбоо, мэдээллийн технологийн

чиглэлээр ажилладаг алба хаагчдын ажлын нөхцөл хүнд, ачаалал их

- Шаардлагатай орон тоонд цэргийн өөр төрөл мэргэжлийн боловсрол эзэмшсэн алба хаагчдыг сурган, дадлагажуулж ажиллуулахад идэвх сул, ирээдүйн карьерын өсөлтдөө итгэл үнэмшилгүй болдог зэрэг нь холбоо зохион байгуулалтад сөргөөр нөлөөлөх хүчин зүйл болж байна.

Холбоо, мэдээллийн технологийн хөгжилтэй хөл нийлүүлэн шаардлагатай байгаа бүтэц, зохион байгуулалт, бүрэлдэхүүнийг оновчтой болгох, үйл ажиллагааных нь үр ашгийг дээшлүүлэхгүй бол алба үйл ажиллагаа тасалдах, цэргийн холбооны инженер, техникчийн үнэлэмж бага учир чадварлаг боловсон хүчнээ алдах, цаашлаад нууц мэдээлэл алдагдах зэрэг эрсдэлтэй.

Цаашид мэдээллийн технологийн хөгжлийг даган шинээр гарч ирсэн албан тушаал, орон тоог батлах;

Алба хаагчдыг гадаад, дотоодын цэргийн их дээд сургууль, академид удирдлагын холбоо, мэдээллийн технологи, кибер аюулгүй байдлын чиглэлээр сургах, мэргэшүүлэх;

Мэдээлэл технологийн нарийн мэргэжлийн инженерүүдийг гаднын их, дээд сургуулиудаас сонгон шалгаруулалтаар авах;

Хилийн цэргийн ангиудад ажиллаж байгаа инженерүүдийн орон тоог нэмж, төрөлжүүлэх;

Холбоо, мэдээлэл технологийн инженер, техникч, холбоочдын

ажлын үнэлэмж, хангамжийг дээшлүүлэх;

Хилийн цэргийн 0151 дүгээр ангийн Холбооны сургалтын төвийг өргөжүүлж зөвхөн холбоочин бэлтгэхээс гадна инженер, техникчдийг мэргэшүүлэх сургалтыг явуулах боломжтой байна.

Техник хангамжийн хувьд:

Улсын хил хамгаалалтыг радио, цахилгаан, сансрын, шуудан холбоогоор байнгын, тасралтгүй, найдвартай удирдлагаар хангаж, хил хамгаалалтын мэдээллийн сүлжээ, хилийн шалган нэвтрүүлэх мэдээллийн сүлжээ, харилцан ажиллагааны холбоо, мэдээллийн сүлжээг зохион байгуулж, техник болон программ хангамжийн шинэчлэлийг үе шаттайгаар хийсээр байна.

Улсын мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтэц бүхэлдээ тоон технологид шилжсэн, үндэсний хиймэл дагуулыг хөөргөх сансрын байршилтай, техникийн стандарт, шийдэл, технологийн өргөн хүрээтэй сонголт хийх боломжтой мөн өдөр хөгжилтэй орнуудтай гадаад хамтын ажиллагаа өргөжиж, цэргийн холбооны шинэ техник, технологиор дэмжлэг үзүүлэх эхлэл тавигдсан зэрэг давуу талуудтай.

Хэдий ийм боловч ХИЦ-ийн холбоод ашиглагдаж байгаа техник хэрэгслүүдэд дараах дутагдлууд байсаар байна. Үүнд

- Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 233 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын заалт зөрчигдсөн;

- ХХБ-ын радио холбооны бэлэн байдал алдагдсан;

- ХХБ-ын холбоо, мэдээллийн технологийн техникийн хангалт, техник хэрэгслийн нөөц дутмаг;

- Албанд ашиглагдаж буй болон өөр хэл дээр бичигдсэн программ хангамжуудыг хөгжүүлэх, нэгдсэн мэдээллийн сангийн нийцлийг хангахад хүндрэлтэй;

- Техник технологийн хувьд өөрийн үйлдвэрлэл байхгүй, хараат байдал;

- Цэргийн зориулалтын байнгын болон хээрийн холбооны аналог хэрэгслүүдтэй;

- Мэдээлэл солилцох хурд багтаамж өнөөгийн шаардлагаас хэт доогуур

Төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллагын сүлжээний дэд бүтэц нь хувийн хэвшлийн байгууллагаас хамааралтай байгаа нь өөрөө маш том эрсдэлийг дагуулж байна.

Ашиглалтын хугацаа дууссан техник болон нөхөн хангагдаагүй техник хэрэгслийн хангалтыг хийхгүй бол удирдлага алдагдах өндөр эрсдэлтэй.

Кибер аюулгүй байдал, мэдээллийн системийн эмзэг байдал нь Зэвсэгт хүчний шинэ мэдээллийн технологийн сонголт, шийдэлд нөлөөлөх магадлал өндөр эрсдэлтэй байна

Бидэнд дараах боломжууд нээлттэй байна. Үүнд

Гадаад, дотоодын төсөл, хөтөлбөр, хөрөнгө оруулалтаар техникийн шинэчлэл хийх;

Программ хангамжуудыг нэгтгэх, нэгдсэн мэдээллийн сан байгуулах;

Хилийн цэргийн 0151 дүгээр ангийн Холбооны засварын төвд

цэргийн холбооны зориулалттай холбооны зарим хэрэгсэл үйлдвэрлэх, угсрах боломжтой.

Иймд Хил хамгаалах байгууллагын холбоо, мэдээллийн технологийн системийг аюулгүй байдлыг ханган зохион байгуулахын тулд системийн удирдлагын менежмент хийх шаардлага тулгарч байна.

*Өмнөө тавьсан зорилгодоо хүрэх үүднээс дээд зэргийн үр ашиг, үр дүн бий болгохын тулд байгууллага, хөдөлмөрийн хамт олон, ажилчдын хөдөлмөрийн бүтээмжид тасралтгүй нөлөөлөх тэр үйл явцыг байгууллагын удирдлага буюу байгууллагыг удирдах үйл явц гэж нэрлэдэг.*⁴

*Менежмент гэдэг нь байгууллагын зорилтыг тодорхойлж, түүнд хүрэх замыг нарийн тодорхойлж, үйлдвэрлэлийн нөөцүүдийн ашиглалтыг оновчтой зохион байгуулж, хүмүүсээ идэвхжүүлэн манлайлж, улмаар ажлын үр дүнг үнэлэн хяналт тавих үйл ажиллагаануудын нэгдэл юм.*⁵

Цэргийн удирдлага бол төрийн удирдлагын онцгой төрөл юм. Төрийн удирдлагын онцгой төрөл байдгийн учир нь байлдааны зэвсэг, тусгай зориулалтын техниктэй, түүнийг хуулийн дагуу хэрэглэх эрх бүхий төрийн цэргийн байгууллагуудыг удирддагт оршино.

Цэргийн удирдлагын зорилго нь цэргийн байгууллага, түүний


бүрдэл хэсгүүдийн бүтэц, бүрэлдэхүүн, тоо хангамжийг тодорхойлох, зориулалт болон гүйцэтгэх үүргээрээ цэргийн байгууллагын хүрсэн түвшнийг хадгалах болоод өөрчлөн сайжруулах, үйл ажиллагааны дэг журмыг цэгцлэн тогтоох, цэрэг, үйл ажиллагааны дэг журмыг цэгцлэн тогтоох, цэрэг-улс төр, цэрэг стратегийн нөхцөл байдалд нийцүүлэн цэргийн байгууллагын бүрдэл хэсгүүдийг тухай бүрд нь шинэ байдлаар өөрчлөн зохион байгуулахад оршино.

Цэргийн удирдлагын үндсэн агуулга нь улс орны цэргийн байгууллага, түүний бүрдэл хэсгүүдийн хөгжлийн зорилго, зорилтууд, үйл ажиллагаа явуулах нөхцөл бололцоо, бэлтгэх болон ашиглах чиглэлийг тодорхойлох, улс орны тайван болон дайны цагийн эрх зүйн хэм хэмжээний актуудаар баталгаажсан удирдлагын эрх дарх, чиг үүргийг хэрэгжүүлэх явдал юм.

4

<http://gerganmanagement.blogspot.com/2015/06/3.html>

⁵ <https://mn.wikipedia.org/wiki>



Хил хамгаалах байгууллагын холбоо, мэдээллийн технологи, кибер аюулгүй байдлын чиглэлийн удирдлага зохион байгуулалтыг шинэчилж боловсруулахын тулд дараах алсын хараа, зорилго тодорхойллоо.

Алсын хараа: Холбоо, мэдээлэл технологийн дэвшил нь Улсын хил хамгаалалтын тулгуур байна.

Зорилго: Салбарын удирдлага, зохион байгуулалтыг үр дүнтэй схемчлэн, дэвшилтэт технологийг нэвтрүүлж, мэдлэг оюунд тулгуурласан байгууллагыг цогцлоон хөгжүүлнэ.

Дүгнэлт, санал

Холбоо, мэдээллийн технологи, кибер аюулгүй байдлын хөгжлийн чиг хандлага, техник технологийн ололт, үйлдвэрлэл инновацыг тооцож, зохицуулалтын үйл ажиллагааг төлөвлөх, хууль эрхзүйн орчныг шинэчлэх, учирч буй шинэ хүндрэл бэрхшээл зэргийг харгалзан өөрийн орны салбарын зохицуулах байгууллагын үйл

ажиллагаанд дүн шинжилгээ хийж, нийцүүлэх нь чухал гэж үзэж байна.

ХХБ-ын удирдлагын холбоо, мэдээллийн системийг олон улсын жишигт хүргэх, мэдээлэл холбооны тэргүүлэх техник технологиудыг цэргийн хэрэгт нэвтрүүлэх, цэргийн ажиллагаанд шаардагдах холбоо, мэдээллийн хангалт, төлөвлөлт менежментийг боловсронгуй болгох, салбартаа тэргүүлэх мэдээллийн мэргэжилтнүүдийг сурган дадлагажуулах, цэргийн удирдлагын улам бүр өсөн нэмэгдэж мэдээллийн хэрэгцээ шаардлагад нийцсэн мэдээлэл холбооны техник технологи бүхий цэрэг, зэвсгийг удирдах системүүдийг бий болгох зэрэг олон чухал асуудлыг шийдвэрлэх шаардлага тавигдаж байна.

Цэргийн холбоог зохион байгуулах, түүний системийг байгуулахад орчин үед орж буй өөрчлөлт нь холбоо, мэдээллийн техник хэрэгслийн хөгжлийн өнөөгийн хүрсэн түвшин, ашиглалтын онцлогтой холбоотой гэдгийг анхаарах шаардлагатай.